



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/77

Мандалговь

┌ “Тэнчи” ХХК-тай гэрээ байгуулах тухай ┐

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн А/52 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд 12 хүний суудалтай автомашин” нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Тэнчи” ХХК-тай 37,400,000 (гучин долоон сая дөрвөн зуу мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд 12 хүний суудалтай автомашин” нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тэнчи” ХХК-ны захирал (О.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Үйлчилгээний албаны дарга (Ш.Оюун) ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

**482060305**